



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2017 оны 10 дугаар сарын 16

№ 01/173

Мандалговь хот

Г Зөрчил арилгуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Шүүхийн 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрлын аudit хийх явцад нийт 9,198,680.00 /есөн сая нэг зуун ерэн найман мянга зургаан зуун наяа/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ.

Үүнд:

1. Ажил дүгнэсэн баримтгүйгээр нийт 8,495,663.00 төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон.

Энэ нь Хүн амын бодлого, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 тоот тушаалаар баталсан "Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 5-д /ажилтанд олоож байгаа ур чадварын нэмэгдлийг засан хязгаарт багтаан нэмэгдүүлэх буруулах асуудлыг улирал бүр хэлэлцэн шийдвэрлэж байна/, 6-д /энэхүү нийтлэг журмыг үндэслэн байгууллагын захиргаа нь тухайн албан хаагчид эрхэлж буй ажлын ур дүнгээр ур чадвар олгох бусад шалгуур үзүүлэлт, нэмэгдлийн хэмжээ тусгасан журмыг боловсруулан баталж мөрдүүлнэ/ заасныг,

2. Шатахууны зарцуулалтын жишиг нормыг баримтлаагүй, батлагдсан нормоос 423 летр буюу 703,017.00 төгрөгийн шатахуун илүү тооцож зарцуулсан.

Энэ нь Монгол улсын Дэд бүтцийн сайдын 2004 оны 19-р тушаалаар баталсан Автомашины 100км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг мөрдөөгүй тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих,


0000000100

албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-т /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зарчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нэлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Ажил дүгнэсэн баримтгүйгээр ур чадварын нэмэгдэл олгож байгааг таслан зогсоох, цаашид холбогдох журмыг мөрдөх;
2. Шатахууны зарцуулалтын жишиг нормыг баримтлах
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 11 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг Шүүхийн Тамгын газрын дарга А.Лхагвасүрэн, нягтлан бодогч Т.Батмөнх нарт хариуцуулав.



АЛБАН ШААРДЛАГЫГ



¹ Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлэгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанд ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/